



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

“Налайх АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10 дахь хэсэг, 2024 оны 108 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Налайх АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал Ц.Баттулгатай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.“Налайх АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Ц.Баттулгатай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ